

**ИНЖЕНЕР-ГЕОДЕЗИЙН СУДАЛГААНЫ
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ**

2019 оны 6 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар: АТГ-19/10296/30

Улаанбаатар
хот

ЭНЭХҮҮ Инженер-Геодезийн судалгааны ажил гүйцэтгэх гэрээ (цаашид “Гэрээ” гэх)-г Монгол Улсын Иргэний хуулийн 343-358 дугаар зүйл, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.48, Тагнуулын ерөнхий газрын 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 01/834 тоотыг тус тус үндэслэн

Нэг талаас Монгол Улсын хуулийн этгээд болох Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13 хороолол /14230/ Нарны зам-62 Юнион бюлдинг А блок 7 давхар хаягт байрлах, Улсын бүртгэлийн 9012001025 дугаартай, регистрийн 5214203 дугаартай, “МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ” ТӨХК, түүнийг төлөөлж ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ЦЭНГЭЛ (Цаашид “Захиалагч” гэх)

Нөгөө талаас Монгол Улсын хуулийн этгээд болох Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 3-р хороо, Жуулчны гудамж-42 Капитал центр 1203 хаягт байрлах, Улсын бүртгэлийн 9011113073 дугаартай, регистрийн 2791692 дугаартай, “ТЭГШ ХЭМ ГРУПП” ХХК, түүнийг төлөөлж ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ЦЭЦЭГСҮРЭН (Цаашид “Гүйцэтгэгч” гэх, хамтад нь “Талууд” гэх) нар дараах нөхцлийг харилцан тохиролцож байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээний зорилго “Таван толгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын төсөл”-ийн төмөр замын трассын дагуу 290 километрээс Зүүнбаян хүртэлх зайнд тохиролцсон хэмжээнд Инженер-геодезийн судалгааны ажил (цаашид “Судалгааны ажил” гэх) гүйцэтгэхтэй холбоотой холбогдсон Талуудын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход оршино.

1.2. Гүйцэтгэгч нь Ажлыг гүйцэтгэж, Ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгнө. Ажлын гүйцэтгэл нь холбогдох хууль тогтоомж, дүрэм журам, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байна.

1.3. Гэрээгээр гүйцэтгэх Инженер-геодезийн судалгааны ажлыг “Тэгш хэм групп” ХХК нь 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн №01/19 дугаартай “Хамтран ажиллах консорциумын гэрээ”-ний дагуу Улсын бүртгэлийн 9011162037 дугаартай, регистрийн 2694557 дугаартай, “ГЕОСЕТ” ХХК, Улсын бүртгэлийн 9011009077 дугаартай, регистрийн 2686155 дугаартай “ГЕОКАД” ХХК, Улсын бүртгэлийн 9011022002 дугаартай, Регистрийн 2547805 дугаартай “ТАВАН-ҮНДЭС” ХХК-тай хамтран гүйцэтгэнэ.

1.4. Захиалагч нь энэхүү гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлын үр дүн, тайлан, санхүүгийн тооцоог “Тэгш хэм групп” ХХК-тай хийнэ. “Тэгш хэм групп” ХХК нь бусад гүйцэтгэгчийн ажлын үр дүн, баталгаа, санхүүгийн тооцоог Захиалагчийн өмнө хариуцна.

1.5. Гүйцэтгэгч нь Инженер-геодезийн судалгааны ажлыг бүрэн, чанартай хийж дуусгасан болохыг баталж, эрх бүхий байгууллагаар баталгаажуулсан ажлын тайлан болон дагалдах бичиг баримтыг Захиалагчийн өмчлөлд акт үйлдэн шилжүүлсэнээр, Захиалагч гэрээгээр тохиролцсон хугацаанд төлбөр тооцоог барагдуулснаар талуудын үүрэг дуусгавар болно.

1.6. Талууд бизнесийн нэр хүнд, хууль ёсны ашиг сонирхлыг харилцан хүндэтгэж, гэрээний үүргийг тогтоосон газар, хугацаанд нь, зохих ёсоор, шударгаар гүйцэтгэх зарчмыг удирдлага болгон мэргэжлийн ёс зүйг баримталж ажиллана.

1.7. Гэрээ нь үндсэн гэрээ болон гэрээний хавсралтаас бүрдэнэ. Гэрээ болон гэрээний хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг болох бөгөөд зөвхөн гэрээний хамт хүчин төгөлдөр байна.

1.8. Гүйцэтгэгч нь мэргэжлийн ажиллах хүчнээр хангаж ажиллах ба туслан гүйцэтгэгч авч ажиллуулахгүй.

Хоёр. Гүйцэтгэх ажил, түүний үр дүн

2.1 Энэхүү гэрээгээр Гүйцэтгэгч нь Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу Зүүнбаянгаас эхлэн 290-р километр чиглэлд 62 километр газарт Инженер-геодезийн судалгааны ажлыг Гэрээнд заасан хугацаанд, холбогдох хууль тогтоомж, стандартад нийцүүлэн гүйцэтгэнэ.

2.2 Гүйцэтгэгчийн ажлын гүйцэтгэл, Судалгааны ажлын тайлан нь хууль тогтоомж, дүрэм, заавар, үндэсний болон олон улсын стандартад нийцсэн байх бөгөөд төрийн эрх бүхий байгууллагаар хянуулж, дүгнэлт (Хөндлөнгийн хяналт) гаргуулсан байна.

2.3 Ажлыг энэхүү гэрээний хавсралтаар батлагдсан ажлын даалгаврын дагуу гүйцэтгэнэ. Ажлыг гүйцэтгэхдээ гэрээний хавсралтад заасан цар хүрээгээр хязгаарлагдахгүй бөгөөд хууль тогтоомж, дүрэм журамд заасан ажлыг зохих ёсоор бүрэн гүйцэтгэнэ.

2.4 Гүйцэтгэгч нь багажны өндөржилт болон системийн тохиргоог Захиалагчийн төлөөлөгчийн сонгосон газарт хийнэ.

2.5 Судалгааны ажил эхлэх, төгсөх цэгийг Захиалагчийн төлөөлөгч тогтооно.

2.6 Ажлын үр дүн болох судалгааны ажил, ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт, тоон мэдээлэл, түүхий дата болон түүнд хавсаргасан фото, схем зураг, диаграм болон бусад холбогдох дагалдах зүйлс нь захиалагчийн өмч байна.

2.7 Талууд ажлын гүйцэтгэлийн хувь хэмжээ, явц, чанарын талаар харилцан тохиролцож чадаагүй, эсхүл аль нэг талын гаргасан тайлбар, үндэслэл, дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй, тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол захиалагчийн сонгосон шинжээчээр дүгнэлт гаргуулна. Ийнхүү дүгнэлт гаргуулахад гарсан нэмэлт зардлыг ажил Гүйцэтгэгч бүрэн хариуцна.

Гурав. Ажил гүйцэтгэх хугацаа

3.1 Ажил гүйцэтгэгч нь Судалгааны 2019 оны 06 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн 2019 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл 21 хоногийн дотор гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж хүлээлгэн өгнө.

3.2 Гүйцэтгэгч нь хийгдэж буй ажлын тайланг Захиалагчийн шаардсан тухай бүрт Захиалагчид хүргүүлэн ажиллана.

3.3 Ажил гүйцэтгэгчийн үйл ажиллагаа, зохион байгуулалт, ажил гүйцэтгэхэд шаардагдах техник тоног төхөөрөмжийг тээвэрлэхэд гарсан аливаа саатал, эрсдэл, санхүүгийн хүндрэл, энэ гэрээнд заасны дагуу ажлын гүйцэтгэлийн доголдлыг арилгасан зэрэг нь ажил гүйцэтгэх хугацааг хойшлуулах үндэслэл болохгүй.

3.4 Ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй, эсхүл хугацаа хожимдуулж нь ажил гүйцэтгэгчид захиалагчийн зүгээс энэ гэрээнд заасан алданги болон гүйцэтгэсэн торгууль ногдуулах үндэслэл болно.

Дөрөв. Ажлын хөлс

4.1 Энэхүү гэрээнд заасан ажлыг гүйцэтгэх ажлын хөлс нь нийт 363.755.448 /гурван зуун жаран гурван сая долоон зуун далан таван мянга дөрвөн зуун дөчин найман/ төгрөг /цаашид "Ажлын хөлс" гэх/ байна.

4.2 Ажлын хөлсөнд НӨАТ болон холбогдох бүх төрлийн татвар, хураамж үндсэн ажлын зардал болон хяналтын зардал, тайланг эрх бүхий байгууллагаар батлуулах зардал, бусад холбогдох зардлууд багтсан болно.

4.3 Ажил гүйцэтгэх хугацаанд ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай үндсэн бараа, материал, түлшний үнэ өссөн, Засгийн газраас хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэмэгдүүлэн тогтоосон болон Захиалагчаас үл шалтгаалах байдлаар ажлын өртөг нэмэгдэхтэй холбогдсон эрсдэлийг Гүйцэтгэгч бүрэн хариуцна. Судалгааны ажлыг Захиалагчийн гаргаж өгсөн Ажлын даалгаварын хүрээнд гүйцэтгэхэд тооцоолоогүй гарсан зардлыг Гүйцэтгэгч хариуцах бөгөөд Гэрээнд үнийн тохируулга хийгдэхгүй.

4.4 Гэрээгээр гүйцэтгэх судалгааны ажлын хөлсийг гүйцэтгэлээр нь санхүүжилт хийнэ.

4.5 Гүйцэтгэгч нь судалгааны ажлын тайлан (цэгийн хайгуул судалгаа, полигнометрийн цэгийн суулгалт, геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэрэг, GPS сүлжээний үндсэн болон зураглалын сүлжээний хээрийн хэмжилт хийгдсэн байдлаар)-г Захиалагчийн томилсон эрх бүхий этгээд хүлээн авсанаар гэрээний дагуу төлөх ажлын хөлсний 40 хувьтай тэнцэх хэсгийн 145,502,179.2 /нэг зуун дөчин таван сая таван зуун хоёр мянга нэг зуун далан есөн/ төгрөгийг ажлын 5 өдөрт багтаан төлнө.

4.6 Гүйцэтгэгчийн судалгааны ажлын тайланг төрийн эрх бүхий байгууллага хянаж дүгнэлт гаргасан болон Захиалагчийн томилсон эрх бүхий этгээд ажлыг чанартай гүйцэтгэсэнд тооцож акт үйлдэн хүлээн авсанаар ажлын хөлсний 55 хувьтай тэнцэх хэсгийн 200,065,496.4 /хоёр зуун сая жаран таван мянга дөрвөн зуун ерин зургаа/ төгрөгийг ажлын 10 хоногт багтаан төлнө.

4.7 Гэрээний үнийн 5 хувийг Гүйцэтгэгч нь ажлын чанарын баталгаа болгон үлдээх ба Захиалагчид хүлээлгэн өгсөн өдрөөс хойш 6 сар хугацаанд Захиалагчийн дансанд барьцаанд үлдээнэ.

4.8 Захиалагч тал төлбөрийг гүйцэтгэгч "Тэгш хэм групп" ХХК-ийн ХААН банкны 5115040368 тоот дансанд шилжүүлсэн өдрийг ажлын хөлсийг төлсөн өдөрт тооцно.

Тав. Баталгаа

5.1 Гүйцэтгэгч нь гэрээний дагуу ажил гүйцэтгэх, гэрээнээс үүсэх эрх, үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй, энэхүү гэрээг байгуулах, бүртгүүлэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай тусгай зөвшөөрөл, эрхийг эрх бүхий байгууллагаас авсан, тэдгээр нь гэрээний үүргийг зохих ёсоор бүрэн гүйцэтгэж дуусах хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр, гэрээнд заагдсан ажлыг гүйцэтгэх боловсон хүчний болон санхүүгийн бүрэн чадамжтай гэдгийг үүгээр баталж байна.

5.2 Гүйцэтгэгч нь ажлыг хууль тогтоомж болон энэ гэрээнд заасан шаардлагад нийцүүлэн, эрхийн болон биет байдлын доголдолгүй, холбогдох бичиг баримт нь үнэн зөв, бүрэн гүйцэд хүлээлгэж өгнө гэдгийг үүгээр баталж байна.

5.3 Талууд энэхүү Гэрээг байгуулахтай холбогдуулан мэдсэн нөгөө талын үйл ажиллагаатай холбоотой нууц мэдээллийг тухайн талын зөвшөөрөлгүйгээр хууль болон энэ гэрээнд зааснаас бусад тохиолдолд бусдад задруулахгүй, энэхүү гэрээнээс үүссэн харилцаанаас өөр бусад зорилгоор ашиглахгүй байхыг үүгээр баталж байна.

Зургаа. Хууль тогтоомж, гэрээг тайлбарлах

6.1 Талууд энэхүү гэрээг Монгол Улсын хууль тогтоомжид үндэслэн, эрх бүхий байгууллагаас баталсан аливаа дүрэм, журам, заавар, стандарт, шаардлагад нийцүүлэн талуудын хоорондын эрх тэгш, харилцан ашигтай байх зарчимд тулгуурлан байгуулав.

6.2 Гэрээний зүйл заалт, үг, өгүүлбэрийг энэ гэрээнд заасан нэр томъёог үндэслэн тайлбарлах бөгөөд хэрэв энэ гэрээнд тайлбарлаагүй тохиолдолд гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлана. Хэрэв гэрээний агуулгад нийцүүлэн тайлбарлах боломжгүй тохиолдолд гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Монгол Улсын хуульд заасныг баримтална.

Долоо. Гэрээг байгуулсанд тооцох

7.1 Гэрээнд талуудын төлөөлөх эрхтэй этгээд гарын үсэг зурж баталгаажуулснаар гэрээ хүчин төгөлдөр болно.

7.2 Гэрээг монгол хэлээр хоёр хувь үйлдэх ба Гүйцэтгэгч нэг хувийг, Захиалагч нэг хувийг тус тус хадгалах бөгөөд хууль зүйн адил хүчинтэй байна.

7.3 Талууд гэрээг бүртгүүлэх, батлуулах шаардлагатай тохиолдолд түүнтэй холбоотойгоор холбогдох бүхий л баримт бичиг, мэдээллийг гарган өгч хамтран ажиллана.

7.4 Талууд гэрээ байгуулахтай холбогдон гарсан өөрсдийн зардлыг өөрөө хариуцах бөгөөд гэрээг нотариатаар гэрчлүүлэх тохиолдолд зардлыг ийнхүү гэрчлүүлэх хүсэлт гаргасан тал, бүртгүүлэх батлуулах тохиолдолд тийнхүү үүрэг хүлээсэн тал зардлыг хариуцна.

Найм. Ажлын доголдлыг арилгах, Гомдлын шаардлага гаргах

8.1 Гүйцэтгэгч нь ажлыг чанаргүй гүйцэтгэсэн, эсхүл захиалагчийн болон эрх бүхий хяналтын байгууллагын бичгээр өгсөн чиглэл, удирдамжийг зөрчиж гүйцэтгэсэн нь ажлын гүйцэтгэлийг хянах явцад болон энэ гэрээний гомдлын шаардлага гаргах хугацаанд илэрсэн бол уг зөрчлийг өөрийн хөрөнгөөр засаж доголдлыг арилгах, үүнээс үүсэн захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг бүрэн хариуцах үүрэгтэй.

8.2 Гүйцэтгэгч ажлын үр дүнгийн доголдлын талаар санаатай нуун дарагдуулсан нь хожим илэрвэл тэрээр хариуцлагаас бүрэн буюу хэсэгчлэн чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд захиалагч болон гуравдагч этгээдэд учирсан шууд болон шууд бус хохиролыг бүрэн хариуцна.

8.3 Гүйцэтгэгч гэрээний нөхцөлийг зөрчсөн буюу гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол байвал захиалагч энэ тухай гомдлын шаардлагыг ажил хүлээн авснаас хойш гурван жилийн дотор гомдлын шаардлага гаргах эрхтэй.

Ес. Талуудын мэдээлэл солилцох

9.1 Гэрээний талууд үйл ажиллагаа эрхлэн явуулахад шаардлагатай мэдээллийг харилцан солилцож байна.

- 9.2 Мэдээллийг бичгээр болон факс, и-мэйл зэрэг цахим хэлбэрээр солилцоно.
- 9.3 Хойшлуулшгүй тохиолдолд талууд мэдээллээ амаар болон утсаар солилцож болох боловч ийнхүү солилцсон мэдээллээ баталгаажуулж 48 цагийн дотор нөгөө талд хүргүүлнэ.
- 9.4 Мэдээлэл солилцооноос үүсэх хохиролыг захиалагч хариуцахгүй.
- 9.5 Захиалагч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай мэдээ баримт, судалгаа, зааварчилгааг ажил гүйцэтгэгчийн хүсэлтийн дагуу гаргаж өгнө.

Арав. Ажлын үр дүн, Ажлын бичиг баримт хүлээлцэх

- 10.1 Талуудаас тус бүр 2 /хоёр/-оос доошгүй төлөөлөлтэйгөөр ажлын үр дүнг хэлэлцэж, протокол үйлдэж, ажлын үр дүн, судалгааны ажлын тайланг хүлээлцэнэ.
- 10.2 Талууд гэрээний дагуу ажлын гүйцэтгэлийг хүлээлцсэнээс хойш 3 /гурав/ хоногийн дотор ажлын бичиг баримтыг акт үйлдэнэ.
- 10.3 Гүйцэтгэгч нь судалгааны ажлын тайлан, эх материал, солбицлын жагсаалт, тоон мэдээлэл, түүхий дата болон түүнд хавсаргасан фото, схем зураг, диаграм, цаашид ажиллах боломжтой цахим файл болон холбогдох бүх материалыг Захиалагчид бүрэн шилжүүлэн өгнө.
- 10.4 Бичиг баримтыг хүлээлцэхдээ бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг шалган, Захиалагч бичиг баримтын эх хувийг хүлээн авна. Гүйцэтгэгч бичиг баримтын бүрдэл бүрэн гүйцэт, үнэн зөв эсэхийг хариуцан хүлээлгэн өгнө.

Арван нэг. Захиалагчийн эрх, үүрэг

- 11.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Гүйцэтгэгчээс шаардах эрхтэй;
- 11.2. Ажлын явцын тайлан, мэдээг тухай бүр Гүйцэтгэгчээс гаргуулан авах;
- 11.3. Гүйцэтгэгч талын гүйцэтгэж буй судалгааны ажил, бусад дагалдах ажилд хяналт тавих, тухай бүр шалгах, шаардлага тавих;
- 11.4. Гүйцэтгэгч талын үйл ажиллагааны алдаа, зөрчлүүдийн улмаас үүсэн гарсан аливаа хохирлыг нөхөн төлүүлэх, судалгааны ажлын тайлан, дүгнэлтийн хувьд гарсан бүх алдаа, зөрчлийг үнэ төлбөргүй дахин боловсруулах, шинэчлүүлэх талаар шаардлага тавих;
- 11.5. Шаардлагатай тохиолдолд судалгааны ажлын гүйцэтгэлд нарийн мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт, шалгалт хийлгэх эрхтэй.
- 11.6. Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хугацаанд төлөх үүрэгтэй;
- 11.7. Судалгааны ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд өөрсдийн зүгээс шаардлагатай туслалцааг Гүйцэтгэгчид үзүүлэх үүрэгтэй;
- 11.8. Захиалагчийн зүгээс судалгааны ажил хийж гүйцэтгэхтэй холбогдсон шаардлагатай мэдээ, мэдээллээр хангах;
- 11.9. Энэхүү гэрээнд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлнэ,

Арван хоёр. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг

- 12.1 Гэрээгээр хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэхийг Захиалагчаас шаардах эрхтэй;
- 12.2 Гэрээнд заасны дагуу гэрээний төлбөрийг хүлээн авах эрхтэй;
- 12.3 Захиалагч талаас гаргаж өгөх судалгааны ажлын хүрээн дэх мэдээ материалыг боломжит цаг хугацаанд нь шаардан авах эрхтэй;
- 12.4 Захиалагчтай судалгааны ажлын тайлан, дүгнэлт дээр санал зөрөлдсөн тохиолдолд судалгааны ажлын гүйцэтгэлд мэргэжлийн байгууллагаар хөндлөнгийн хяналт хийлгэх эрхтэй.
- 12.5 Судалгааны ажлыг Захиалагчаас өгсөн Ажлын даалгаврын дагуу, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, норм, Олон улсын болон Үндэсний стандартад нийцсэн байдлаар, сүүлийн үеийн баталгаажсан техник, технологийг ашиглан гүйцэтгэн, хүлээлгэн өгөх үүрэгтэй;
- 12.6 Судалгааны ажлын үр дүн, тайлан дүгнэлтийг төрийн эрх бүхий байгууллагаар хянуулж, дүгнэлт гаргуулсан байна;
- 12.7 Судалгааны ажлын үр дүн, тайлан дүгнэлтэд тусгагдсан норматив болон тооцооны үзүүлэлтүүдийн үнэн зөвийг бүрэн хариуцах;
- 12.8 Судалгааны ажил, тайлан дүгнэлттэй холбогдсон алдаа, зөрчил, Ажлын даалгаврын дагуу гүйцэтгэгдээгүй ажил бий болсон тохиолдолд Захиалагчид дахин үнэ төлбөргүйгээр засч өгөх, хохирлыг барагдуулах үүрэгтэй\;
- 12.9 Судалгааны ажлыг хэрэгжүүлэх тухай ажлын арга, аргачлал болон гүйцэтгэх хугацааг үе шат тус бүрээр хөтөлбөр боловсруулан Захиалагчид танилцуулах үүрэгтэй;
- 12.10 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үйл ажиллагааг хариуцах үүрэгтэй;
- 12.11 Энэхүү гэрээнд заасан бусад хуулиар эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

Арван гурав. Нууцлал

- 13.1 Талууд, тэдгээрийн ажилтан Гэрээний хэрэгжилттэй холбоотой аливаа баримт бичиг, мэдээллийг харилцан дамжуулах, солилцох, хадгалах, хамгаалахдаа Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журмыг чанд мөрдөх үүрэгтэй.
- 13.2 Талууд энэхүү Гэрээний нөхцөл, судалгааны ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор нөгөө Талын шууд ба шууд бусаар олж авсан (үүнд гэрээ байгуулахаас өмнө эсхүл хойно, гэрээ цуцлагдсаны дараа) аливаа мэдээллийг задруулахыг хориглоно.
- 13.3 Судалгааны ажил гүйцэтгэхтэй холбоотой материалыг Талуудын зөвхөн нууцтай танилцах эрх бүхий ажилтан, албан тушаалтан танилцана.
- 13.4 Гэрээ нь Байгууллагын нууцад хамаарах бөгөөд хуульд зааснаас бусад тохиолдолд гэрээний талаархи аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно.
- 13.5 Талуудын аль нэг нь энэ зүйлд заасан үүргээ зөрчсөний улмаас нөгөө талын бизнесийн нэр хүндэд ноцтой хохирол учирсан, материаллаг хохирол учруулсан бол

буруутай тал нь түүнийг бүрэн хариуцна.

Арван дөрөв. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах

14.1 Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг Талууд харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

14.2 Талууд гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд нөгөө Талдаа саналаа бичгээр хүргүүлэх бөгөөд тухайн саналд нэмэлт, өөрчлөлтийн үндэслэл, түүний төслийг тусгана.

14.3 Саналыг хүлээн авсан тал ажлын 14 хоногийн дотор хариу ирүүлэх үүрэгтэй бөгөөд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, цуцлах асуудлыг шийдвэрлэнэ.

14.4 Гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний салшгүй хэсэг байна.

Арван тав. Гэрээний зөрчлийг арилгах, гэрээ цуцлах

15.1 Талууд гэрээний үүргийн зөрчлийг арилгах тухай нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдлийг хүлээн авсан тал гэрээний зөрчлийг 5 хоногийн дотор арилгаж хариу мэдэгдэх үүрэг хүлээнэ.

15.2 Хэрэв зөрчил гаргагч Тал зөрчлийг 5 хоногийн дотор арилгах боломжгүй бол энэ тухай нөгөө Талдаа мэдэгдэх бөгөөд зөрчил арилгах хугацааг Талууд харилцан тохиролцож тогтооно.

15.3 Талууд гэрээг цуцлах саналтай байгаа бол уг саналаа нөгөө Талд бичгээр хүргүүлж, харилцан тохиролцож шийдвэрлэнэ.

15.4 Захиалагч нь дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.4.1 Гүйцэтгэгч энэ гэрээний дагуу ажил гүйцэтгэх хуваарь болон хугацааг 5 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн;

15.4.2 Гүйцэтгэгч ажил гүйцэтгэхдээ чанарын ноцтой доголдол гаргасан бөгөөд захиалагч ажлыг цаашид үргэлжлүүлэн гүйцэтгэх боломжгүй гэж үзсэн;

15.4.3 Гүйцэтгэгч нь ажлын доголдлыг боломжит хугацаанд арилгаагүй, эсхүл ийнхүү арилгахаас зайлсхийсэн;

15.4.4 Гүйцэтгэгчийн баталгаа нь хуурамч болох нь илэрсэн;

15.4.5 Гэрээгээр хүлээсэн үүргээ ноцтой зөрчсөн.

15.5 Гүйцэтгэгч дараах тохиолдолд гэрээг дангаар цуцлах эрхтэй. Үүнд:

15.5.1 Захиалагч төлбөрөө шилжүүлэх хугацааг 20 буюу түүнээс дээш хоногоор хэтрүүлсэн, цаашид боломжит хугацаанд шилжүүлэхгүй нь тодорхой болсон;

15.5.2 Захиалагч ажлын хамрах хүрээг өөрчилсөн нь энэхүү гэрээнд заасан ажлын хөлсийг нэмэгдүүлэх нөхцөл байдлыг бий болгосон бөгөөд захиалагч нэмэлт санхүүжилтийг гаргахаас үндэслэлгүйгээр татгалзсан;

15.5.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ 2 буюу түүнээс дээш удаа ноцтой зөрчсөн.

15.6 Гэрээг цуцалсан тохиолдолд ийнхүү цуцалснаас хойш ажлын 3 хоногийн дотор гэрээ цуцалсан өдрөөр тасалбар болгон Захиалагч Гуравдагч ажил гүйцэтгэгчээр ажлыг гүйцэтгүүлэх эрхтэй.

15.7 Гэрээнд заасны дагуу аль нэг Талын санаачилгаар Гэрээг цуцалсан бол буруутай Тал ийнхүү цуцалсантай холбоотой зардал болон нөгөө Талд учирсан хохирлыг нөхөн төлнө.

Арван зургаа. Хариуцлага

16.1 Гүйцэтгэгч нь ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги төлнө.

16.2 Гэрээг захиалагчийн санаачлагаар цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч гэрээний нийт үнийн дүнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний торгууль хүлээх бөгөөд захиалагчид учирсан хохирлыг бүрэн хариуцна.

16.3 Захиалагч нь энэ гэрээнд заасан үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй бол ийнхүү хугацаа хэтрүүлсэн хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0,1 хувьтай тэнцэх хэмжээний алданги хүлээнэ.

16.4 Аль нэг тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн, гэрээнд заасны дагуу нэг талын санаачилгаар гэрээг цуцалсан бол буруутай тал нөгөө талд учруулсан аливаа хохирол болон зардлыг нөхөн төлнө.

16.5 Хэрэв аль нэг тал нь үүргээ биелүүлээгүй тохиолдолд нөгөө тал нь шаардах эрхээ хэрэгжүүлээгүй бол энэ нь эрхээсээ татгалзсан гэж тооцохгүй бөгөөд эрхээ хожим хэрэгжүүлэх, шаардлагатай арга хэмжээ авахад саад болохгүй.

16.6 Аль нэг тал Гэрээгээр хүлээсэн үүргээ давагдашгүй хүчин зүйлийн улмаас зохих ёсоор биелүүлээгүй болох нь нотлогдвол үүрэг давагдашгүй хүчин зүйлийг арилах хүртэл хугацаагаар хойшлогдоно. Захиалагч төрийн эрх бүхий байгууллагаас хамааралтайгаар гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд саад учирсан тохиолдолд Захиалагчийн үүрэг тухайн нөхцөлийг арилгах хүртэл хугацаагаар хойшилно.

Арван долоо. Маргаан шийдвэрлэх

17.1 Талууд харилцан хүндэтгэлтэй, бизнесийн ёс зүйг чанд сахиж, гэрээтэй холбоотой аливаа маргаан гарахаас урьдчилан сэргийлж ажиллана.

17.2 Энэхүү гэрээг тайлбарлах болон түүний заалтуудыг хэрэгжүүлэхтэй холбогдож гарсан аливаа маргааныг талууд харилцан тохиролцож шийдвэрлэхийг эрхэмлэнэ.

17.3 Талууд харилцан тохиролцоонд хүрэх боломжгүй тохиолдолд Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.

Арван найм. Гэрээний хавсралт

18.1 Хавсралт-1: Дорноговь аймгийн Сайншанд сумын нутаг дахь Зүүнбаян өртөөнөөс Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Тавантолгой нүүрсний орд хүртэлх төмөр замын Инженер-Геодезийн судалгааны ажлын даалгавар.

18.2 Хавсралт-2: Нууцлалын баталгаа.

18.3 Хавсралт-3: 2019 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн № 01/19 дугаартай “Хамтран ажиллах консорциумын гэрээ”

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

ЗАХИАЛАГЧ ТАЛ

"МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ" ТӨХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЦЭНГЭЛ

Утас:

ГҮЙЦЭТГЭГЧ ТАЛ

"ТЭГШ ХЭМ ГРУПП" ХХК, ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ



Д.ЦЭЦЭГСҮРЭН

Утас:

99118158

АЖЛЫН БИЧИГ БАРИМТ ХҮЛЭЭЛЦСЭН АКТ

2019 оны 06 дугаар сарын 13 -ний өдөр

№ 01.

Улаанбаатар хот

Нэг талаас: Гүйцэтгэгч “Тэгш хэм групп” ХХК

Нөгөө талаас: Захиалагч “Монголын төмөр зам” ТӨХК гэрээнд заасныг үндэслэн энэхүү Ажлын бичиг баримт хүлээлцсэн актыг үйлдэж баталгаажуулав.

Талуудын хүлээлцсэн бичиг баримтууд:

№	Бичиг баримтын нэр	Огноо	Дугаар	Тайлбар
1	Ашигш даалгавар			Уясаар
2	ТТ-ЗБн 124км төмөр замын трассын зураг	2019.06.13	=	СД-ыг буулгав.
3	-	-	-	-
4	-	-	-	-

БИЧИГ БАРИМТ ХҮЛЭЭЛЦСЭН:

Захиалагчийг төлөөлж:

Суурь бүтцийн ахлах инженер Ж.Энхбаяр

Хуулийн мэргэжилтэн М.Баянзул

Гүйцэтгэгчийг төлөөлж:

Гүйцэтгэх захирал Д.Цэцэгсүрэн



(Handwritten signature)

(Handwritten signature)

БАТЛАВ
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨТЖЛИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН ГЭМГИЙН ДАРГА


С. БАТБОЛД

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН НУТАГ ДАХЬ ЗҮҮНБАЯН
ӨРТӨӨНӨӨС ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЦОГТЦЭЦИЙ СУМЫН НУТАГТ ОРШИХ
ТАВАНТОЛГОЙ НҮҮРСНИЙ ОРД ХҮРТЭЛХ ТӨМӨР ЗАМЫН ИНЖЕНЕР
ГЕОДЕЗИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ДААЛГАВАР**

1. Ажлын зорилго, байршил

1.1 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын 290-р километрээс Зүүнбаян хүртэлх трассын дагуух 1:1000 масштабтай 0,5 метрийн үеийн өндөртэй зураглал хийх.

1.2 Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын трассын дагуу өмнө нь байгуулагдсан Геодезийн үндэслэлийн цэгүүдийг нягтлах, баталгаажуулах.

2. Солбицлын систем ба өндрийн тогтолцоо

Талбайд суулгах репер болон полигонометрийн цэгүүдийн байрлалын хувьд UTM тусгаг, WGS-84 эллипсоидыг ашиглах ба Балтийн тэнгисийн өндрийн тогтолцоонд хийж гүйцэтгэнэ.

3. Геодезийн үндэслэлийн цэг бэлтгэх

Байрлалын сүлжээнд зориулсан полигонометрийн цэгүүдийн 1 км тутам суулгах бөгөөд энэ нь 70 см урттай төмөр бетон цутгамал байна.

Монгол улсын геодезийн үйлдвэрлэлд хэрэглэгдэж буй стандарт бүхий цэгийн төвийг ашиглана.

Полигонометрийн цэгийн гаднах тэмдэглээсийг шуудуу буюу канав татах эсвэл чулуун овоо босгож тэмдэглэнэ. Полигонометрийн цэгүүдийн абрисыг зурж, хол ойр байрлалаас гэрэл зургийг нь авч хувийн хэргийн батлагдсан зааврын дагуу хөтөлнө. Шуудуу канавын хэмжээ "Геодезийн цэг тэмдэгт суулгах заавар"-ын дагуу хийгдэнэ.

4. Байрлалын сүлжээ

GPS-ийн сүлжээгээр тулгуур сүлжээ байгуулах бол полигонометрийн 4-р ангийн сүлжээ байгуулах шаардлагын дагуу хийж гүйцэтгэнэ.

Хэмжилтийн ажилд хэрэглэгдэх багаж, тоног төхөөрөмжийг Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын хэмжилзүйн лабораторид холбогдох шинжилгээ шалгалтыг хийж, баталгаажуулалт заавал хийлгэсэн байна.

GPS-ийн антен болон хүлээн авагчийн шалгалтыг хийлгэсэн байна.

Байрлалын тулгуур сүлжээг GPS-ийн технологиор хийхдээ GPS багажны тохируулгыг дараах байдлаар хийнэ.

- | | |
|--|-----------|
| • Хэмжилтийн горим | статик |
| • Нэгэн зэрэг хэмжигдэх хиймэл дагуулын хамгийн бага тоо | 4 |
| • Хиймэл дагуулын сигнал авах интервал | 15 сек |
| • Хиймэл дагуулын хэвтээ тэнхлэгээс дээших өнцөг | 15 градус |
| • PDOP-ын хамгийн их зөвшөөрөгдөх утга | 4 |
| • Антеныг жинхэнэ хойд зүг рүү 0-10°-ын хооронд чиглүүлнэ. | |
| • Багажийг 1 цэгийн төвд 1 мм-ийн нарийвчлалтайгаар зориулалтын төвлөрүүлэгч хэрэгслээр төвлөрүүлнэ. | |
| • Хэмжилт үргэлжлэх хугацааг зайнаас хамааруулан 1 мөчлөгөөр хийж хоорондын зайг дор дурдсанаар сонгоно. | |
| a. 5 км радиуст 30 минут | |
| b. 5-10 км радиуст 60 минут | |

Дээд сүлжээний хэмжилтийн GPS ашиглан гүйцэтгэх бол 2 реперийн хооронд сэлгэцийн аргаар байгуулна. Харин электрон тахеометрийн сүлжээний хэмжилтийг хийх бол уламжлалт аргуудыг хэрэглэхдээ масштаб болон өндрийн батлагдсан итгэлцүүрийг ашиглана. Зураглалын сүлжээний цэгүүд нь зэргэлдээх 2 талын цэгүүдийг, саадгүйгээр харахаар суулгагдсан байна.


Зураглалын сүлжээний цэгүүд полигонометрийн 4-р ангийн нарийвчлалыг хангасан байна. Хэмжилтэд тавигдах шаардлагуудын талаар байр зүйн зураглал хэсэгт дэлгэрэнгүй өгүүлсэн болно.

5. Өндрийн сүлжээ

Нивелирдлэгийн реперүүдийн хооронд хэмжилтийн ажлын нивелирдлэгийн 3-р ангийн программын дагуу шууд урвуу чиглэлд 8-н тооны аргаар хийнэ. Өөрөөр хэлбэл 3 реперийг дайруулан шууд чиглэлд нивелирдлэгийн хэмжилт хийгээд урвуу чиглэлд мөн дээрх зарчмаар хийгдэнэ.

Рейкнээс багаж хүртэлх хамгийн их зайг 100 метрээс хэтрүүлэхгүй бөгөөд утаа униар, зэрэглээ салхигүй тогтуун байх үед хэмжилтийг хийнэ. Ган тросс болон ролеткээр мөрийн зөрөөг тохируулах бөгөөд нивелирийн хэмжилт хийхээс өмнө рейк хүртэлх зайг багажаар хэмжин тэнцүүлж болно. Нэг станц дээрх мөрийн зөрөө 3 метрээс 1 сэлгэц дэх хуримтлагдсан мөрийн зөрөөг 5 метрээс ихгүй байна. Хэмжилтэд 3 метрээс илүүгүй урттай рейкийг хэрэглэнэ.

Харах цацрагийн хэмжээ газрын гадаргуугаас дээш болон рейкний оройн хэсгээс 0,3 метрээс багагүй байхаар гүйцэтгэнэ. Хэрэглэгдэх рейкнүүд заавал дугуй тэгшлүүртэй байх ба тэгшлүүрийг ажил эхлэхийн өмнө заавал шалгасан байна. Хэмжилтийг явуулахдаа зориулалтын башмак дээр гүйцэтгэнэ. Нивелирдлэгийн шугамыг дээд ангийн 2 хатуу цэгийн хооронд Балтын тэнгисийн өндрийн тогтолцоонд бодно.



Нүүлтийн зөвшөөрөгдөх алдааг $\Delta h = \pm 10 \text{mm}$ томъёогоор тооцож өндөржилтийн зөрүү зөвшөөрөгдөх хэмжээндээ байгаа нөхцөлд засварыг зай станцын тооноос хамааруулан тарааж өндрийг тэгшитгэн бодож гаргана. Өндрийн сүлжээний хэмжилтэнд GNSS (Glonass) GPS-ийн хүлээн авагч ашигласан тохиолдолд нивелирдлэгийн шалгалтыг нийт ажлын 30-аас доошгүй хувьд нь заавал хийнэ.

6. Байр зүйн зураглал


Зураглалын ажлыг байрлалын хувьд UTM солбицлын тогтолцоо, WGS84 эллипсоид, Балтын тэнгисийн өндрийн тогтолцоонд хийж батлагдсан масштаб болон өндрийн итгэлцүүрийг хэрэглэж гүйцэтгэнэ.

Трассын дагуу байр зүйн 1:1000-ны масштабтай 0,5 метрийн үеийн өндөртэй хийж гүйцэтгэнэ. Байр зүйн зураглалын ажлыг GPS-ийн RTK горим электрон тахеометрийн хэмжилтийн аргаар хийж гүйцэтгэнэ. Зураглалын пикет хоорондын зайг 20 метрээс холгүйгээр (Зураг дээрх пикет хоорондын зай 4 см-ээс ихгүй байх) тооцоолж зураглах ба шаардлагатай газруудад түүнээс бага зайд хэмжилтийг явуулж зураглана.

Зураглалд газар дээрх инженерийн зориулалт бүхий бүх барилга байгууламж, гудамж, зам талбай, төмөр зам, шилэн кабел болон түүний барилга байгууламж, гүүр, нүхэн гарц, гарам янз бүрийн материалаар барьсан хашаа ус зүй, гол, худаг булан тохой далан эрэг ногоон байгууламж атаршсан газар амины орон сууцууд шороо зам ой зэргийг оруулахаас гадна хөрсний өөрчлөлт элс хайрга шавар чулуу зэргийг хүрээлэн контураар үзүүлэн тэмдэглэсэн байна. Ялангуяа эрэг жалга, гуу, суваг шуудуу зэргийг усны ургацын чиглэлд нь тодорхой үзүүлнэ. Мөн талбайд орж байгаа орж байгаа газар доорх инженерийн шугам сүлжээг зураглана. Байр зүйн зураглалын ажилд объект болон контурыг дүрслэн үзүүлэх нарийвчлал байрлалын хувьд 0,10 метр, өндрийн хувьд 0,30 метр (0,15) байх бөгөөд 1:1000 масштабтай 1 метрийн үеийн өндөртэй байр зүйн зураглалын ажлын зааврыг баримтлан хийж гүйцэтгэж тоон байдлаар болон 1:1000-ны масштабтайгаар хэвлэмэл зургийг хүлээлгэн өгнө.

Зурагт хэрэглэсэн таних тэмдэгтийн тайлбар зургийг программын талаарх мэдээллийг тайланд заавал дурдсан байна.

Ажил эхлэхийн өмнө өдөр бүр багажны хээрийн шалгалтыг тогтмол хийж байх ба зураглалын үндэслэлийн цэгүүдээс ойлгогч хүртэлх зайг 500 метрээс холгүй байхаар хэмжилтийг гүйцэтгэнэ. Электрон тахеометрийн хэмжилтэд хэрэглэгдэх ойлгогчийн таяг нь дугуй тэгшлүүртэй байна. Ойлгогчийн призмийн тогтмол фирм фирмээрээ өөр байдаг тул тухайн фирмийн багажид зориулан гаргасан ойлгогчуудыг нь тухайн багажид харгалзуулан хэрэглэнэ. Ойлгогчийн таяг нь ихэнхдээ сунадаг байдлаар хийгдсэн байдаг тул хэрэглээний явцад аажмаар өндрийн тогтмол байх утгаа алддаг. Энэ тал дээр байгууламжийн тооцоо хийгдсэн зураг дээр тооцоологдон хийгдэх тул эрэг жалга, сайрын ёроол болон ирмэгийг тодорхой гаргаж зурагт үзүүлэх шаардлагатай. Иймд пикет хоорондын зайг ойртуулан зурагт эдгээр нь зөв үзүүлэгдсэн байхаар онцлог цэгүүдийг сонгох талаар ойлгогчийг байрлуулж хэмжилтийг гүйцэтгэсэн байна. Мөн зураглалын цэгийн



зогсоол бүр дээр багажид агаарын температур, чийгшилт даралтын өгөгдлүүдийг үнэн зөв оруулж өгнө. Таягны болон ойлгогчийн өндрийг 2 метрээс хэтрүүлэхгүй өндөртэйгээр сонгоно.

7. Хүлээлгэн өгөх материал

Актаар хүлээлгэн өгөх материалын нэр	Хувь
Ажлын нэгдсэн тайлан	4
Сүлжээний нэгдсэн тайлан	4
Техникийн тайлан дараах зүйлүүдийг хавсаргана:	
• Байрлал өндрийн сүлжээний цэгүүдийн каталогийг CD дээр бичсэн хувилбар	4
• Геодезийн байнгын цэг тэмдэгтийн хувийн хэргийн CD дээр бичсэн хуулбар	4
• Сүлжээний бүдүүвч	4
• Сүлжээний RINEX өгөгдлийг CD дээр бичсэн хувилбар	4
• Сүлжээний тэгшитгэн бодолтын тайлан	4
• Сүлжээний цэгүүдийг хүлээлгэн өгсөн акт	
• Хийсэн аргачлал ажилбар бүрээр	4
• Нарийвчлал	4
• Хэрэглэсэн багаж, тоног төхөөрөмжийн мэдээлэл	4
• Цэг тэмдэгтийн тоо төрөл	4
• Тулгуурласан цэг тэмдэгтийн мэдээлэл	4
• Ажлын талбарын мэдээлэл, ажлын нөхцөл	4
• 1:1000-ны масштабтай байр зүйн зургийг CD дээр бичсэн хувь /Триангуляцийн гурвалжингийн хамтаар/	4
Ажил хүлээлгэн өгсөн акт	4

Хянасан:

Зам, тээврийн хөгжлийн
яамны Төмөр зам, далайн
тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга - *ц*
"МТЗ" ТӨХК-ийн Гүйцэтгэх
захирал
"МТЗ" ТӨХК-ийн Дэд
захирал
"МТЗ" ТӨХК-ийн Инженер,
технологийн хэлтсийн
дарга


[Signature]
А.Батболд

[Signature]
Б.Цэнгэл

[Signature]
Р.Батсүх

[Signature]
Д.Нямлхагва


Боловсруулсан:



"МТЗ" ТӨХК-ийн Суурь
бүтцийн албаны ахлах
инженер
"МТЗ" ТӨХК-ийн Замын
ашиглалт хариуцсан
инженер



Ж.Энхбаяр



Э.Ганзориг

--oOo--

